

**САНГИЙН САЙД, БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2009 оны 06 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 139 /134


Улаанбаатар хот

**Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний
1 га талбайн зардлын нормативыг
шинэчлэн батлах тухай**

“Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 15.1.3, “Ойн тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.4.1, 27 дугаар зүйлийн 27.1, 27.3 дугаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний 1 га талбайн зардлын нормативыг хавсралтаар баталсугай.
2. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Ойжуулалт, ойн аж ахуйн зарим арга хэмжээний 1 га талбайн үлгэрчилсэн норматив батлах тухай” Сангийн сайд, Байгаль орчны сайдын 1997 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 404/118 дугаар тушаал, Нормативт зардал шинэчлэн батлах тухай” Сангийн сайд, Байгаль орчны сайдын 1999 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 128/ 104 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


САНГИЙН САЙД




С.БАЯРЦОГТ

ХУУЛБАР ҮНЭН

Төрийн захиргааны удирдлагын газрын дарга




БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД



ГАНСҮХ

Т.Мягмарсүрэн
/2009 оны 6 дугаар сарын 22-ний өдөр/



**ОЙЖУУЛАЛТ, ОЙН АЖ АХУЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ
1 ГА ТАЛБАЙН ЗАРДЛЫН НОРМАТИВ**

д/д	Байгалийн бүс	Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний нэр	Зардлын хэмжээ /төгрөг/
1	Ойт хээрийн	Шилмүүст модны тарьцаар гүйцэтгэх ажил	200.000,0
		Суулгацаар гүйцэтгэх ойжуулалтын ажил	270.000,0
2	Тал хээр, цөлөрхөг хээр, цөлийн	Навчит болон шилмүүст модны тарьцаар ойжуулах ажил	210.000,0
		Навчит болон шилмүүст модны суулгацаар ойжуулах ажил	300.000,0
3	Үрээр ойжуулах ажил:	-Шилмүүст мод -Заг	180.000,0 175.000,0
4	Байгалийн аясаар сэргэн ургалтыг дэмжих ажил		80.000,0
5	“Ногоон хэрэм” хөтөлбөрийн хүрээнд ойн зурвас байгуулах ажил		1100.000,0
6	Ой зохион байгуулалтын ажил		110.000,0
7	Мод бэлтгэлийн талбай тусгаарлах ажил		19.000,0

* * *